

**Монгол Улсын 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих төслүүдийн
төлөвлөлтөд тойм дүгнэлт хийх ажлын даалгавар**

2026 оны 9 дүгээр сар

1. Үндэслэл

Монгол Улсын төсөв өндөр хэмжээний алдагдалтай байгаа энэ үед төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх асуудал хурцаар тавигдаж байна. 2027 оны улсын төсвийн төсвийн төсөл УИХ-д өргөн баригдаад байна. Иймд шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг богино хугацаанд судалж, анхаарах шаардлагатай асуудлуудыг олон нийтийн анхааралд оруулах, УИХ-д санал, дүгнэлт хүргүүлэх нь чухал байна.

2. Судалгааны ажлын зорилго

Энэхүү судалгаа нь Засгийн газраас 2027 онд улсын төсвийн хөрөнгөөр шинээр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан болон батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтөд тойм дүгнэлт өгч, асуудал дэвшүүлэх зорилготой.

3. Гүйцэтгэх ажил

Зөвлөх нь Засгийн газраас 2027 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төслүүдийг хамруулан судалгаа хийхээс гадна УИХ-д өргөн барьсан болон УИХ-аас баталсан хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг харьцуулж судлах юм. Судалгаанд дараах асуудлуудыг хамруулна:

3.1. Төсвийн төсөлд хийх дүн шинжилгээ:

- i. Шинээр хэрэгжих хөрөнгө оруулалтын төслүүд нь нийгэм, эдийн засагт нэн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэж байгаа эсэх;
- ii. Шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төслүүдийн эхний санхүүжилтийг хуулийн дагуу төлөвлөсөн эсэх;
- iii. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төслүүдийг төрлөөр нь ангилан мэдээлэл бэлтгэх, дүгнэлт бичих (тухайлбал, хэдэн тамгын газрын барилга, сургууль, цэцэрлэг төлөвлөсөн гэх мэт);
- iv. Ижил хүчин чадалтай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсөвт өртөгт харьцуулалт хийх (тухайлбал, ижил хүчин чадалтай сургууль, цэцэрлэгийн төсөвт өртөг хэдэн төгрөгийн хооронд хэлбэлзэж байна, хамгийн бага болон өндөр төсөвт өртөгтэй барилга хаана төлөвлөгдөв гэх мэт);
- v. Ижил хүчин чадалтай хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн 2027 онд төлөвлөсөн санхүүжилтийн дүнг харьцуулах.

3.2. УИХ-аас 2027 оны төсвийг батлахдаа Засгийн газраас өргөн барьсан хөрөнгө оруулалтын шинэ төслүүдийн төлөвлөлтөд өөрчлөлт оруулсан эсэхийг судлах. Үүнд:

- 2027 оны төсвийн төсөлд тусаагүй боловч УИХ-аас төсөв хэлэлцэх үед нэмж баталсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний судалгаа хийх (байршлаар (аймаг, нийслэл, дүүргээр), төсвийн ерөнхий захирагчдаар)

- Шинэ төслүүдийн төсөвт өртөгт өөрчлөлт оруулсан эсэхийг судлах.

4. Зорилтот хэрэглэгчид

Судалгааны дүнгийн зорилтот хэрэглэгчид нь бодлого боловсруулагчид болон олон нийт, иргэний нийгэм байна.

5. Хүлээлгэж өгөх бүтээгдэхүүн:

Ажил гүйцэтгэгч нь дараах бүтээгдэхүүнүүдийг хуваарьт заасны дагуу ННФ-д хүлээлгэж өгнө. Үүнд:

	Бүтээгдэхүүн	Хугацаа
1	2027 онд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр УИХ-д өргөн барьсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн шинэ төслүүдийн төсөвт өртгийн судалгааны эхний тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 13-ний дотор
2	Дээрх судалгааны дүнг нийтэд танилцуулах	2026 оны 10-р сарын 22-ны дотор
3	Дээрх судалгааны эцсийн тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 10-р сарын 25-ний дотор
4	УИХ-аас баталсан 2027 оны хөрөнгө оруулалтын шинэ төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төлөвлөлтийг өргөн баригдсан төсөлтэй харьцуулсан судалгааны эхний тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 11-р сарын 24-ний дотор
5	2027 оны төсвийн төсөл, батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн төлөвлөлтийг харьцуулсан судалгааны эцсийн тайланг ННФ-д ирүүлэх	2026 оны 11-р сарын 30-ны дотор

6. Мэдээллийн эх сурвалж

Судалгааг хийхдээ дор дурдсан болон бусад холбогдох баримт бичгүүдийг ашиглана. Үүнд:

- Засгийн газраас УИХ-д өргөн барьсан 2027 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- 2020-2027 онд улсын төсвөөс санхүүжихээр батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт
- Монгол Улсын 2027 оны төсвийн төслийн баримт бичиг (дэлгэрэнгүй танилцуулга, тооцоолол) болон өмнөх онуудын төсвийн гүйцэтгэлийн тайлангууд дахь төсвийн хөрөнгө оруулалтын талаарх мэдээллүүд
- Төсвийн мэдээллийн холбогдох цахим хуудаснууд
- Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын холбогдох хууль, тогтоомжууд
- Холбогдох төрийн байгууллагууд (Сангийн яам, Хөрөнгө оруулалтын газар, Худалдан авах ажиллагааны газар гэх мэт)

- Бусад эх сурвалжууд

7. Ажил гүйцэтгэх хугацаа:

Ажлын удирдамжийн 3-р зүйлд заасан ажлуудыг 2026 оны 10-р сарын 1-нээс 11-р сарын 30-ны хооронд гүйцэтгэнэ.

Судалгааны ажлын төсөв:

Судалгааны хүрээнээс хамаарч судалгааны төсвийн дээд хязгаар 6 сая төгрөг байна.

Зөвлөх нь Нээлттэй нийгэм форумтай нягт хамтран ажиллах ба судалгааны бүтээгдхүүнүүдийг 5-р зүйлд заасан хуваарийн дагуу ирүүлнэ.

8. Судалгааны ажилд тавигдах бусад шаардлага, хэмжээ, хэлбэр

Гэрээт ажилд ашигласан дагалдах материал, судалгааны эх бичвэрийн файл, цахим хуудас зэргийн жагсаалтыг ажлын гүйцэтгэлд хавсаргана.